



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/428

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг, орон нутгийн бүтээн байгуулалт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 210000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 210000 төгрөг /хоёр зуун арван мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/428 Ch
02 02166

Аймгийн Засаг даргын 2019 оны
07 дугаар сарын 02-ны өдрийн
А/428 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Д.Чанцалдулам	Төрийн банкны харилцааны менежер	30000
2	Ц.Цэцэнхараацай	Аймгийн санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч	30000
3	Б.Лхагвасүрэн	Мөст сумын Нийгмийн даатгалын байцаагч	30000
4	И.Оюунжаргал	Жаргалант сумын 2-р сургуулийн нягтлан бодогч	30000
5	Ш.Тогооч	Мөнххайрхан сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	30000
6	Т. Дашням	Дарви сумын малчин	30000
7	Р.Эрдэнээ	Мөст сумын малчин	30000
Дүн			210000

-оОо-